

“ТЭД-АУДИТ” ХХК
Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн
гудамж 40-р байр 3 давхар 7 тоот
УБД: 2097141
Утас: 350953, 99190483
2013.03.01 № 132/02/2013

“ Бэрэн майнинг “ ХК-ийн
Төлөөлөн Удирдах Зөвлөлд

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Хүлээн авагчийн хаяг: Хан-уул дүүрэг, 1-р хороо, ЧӨЧөлөө,
“ Нэхээсгүй Эдлэл ” ХК-ийн байр 3 давхарт

Бид “ Бэрэн майнинг ” ХК-ийн 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн тайлан, орлого үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, жилийн эцсийн мөнгөн гүйлгээний тайлан бусад нэмэлт тайлбар тодруулгыг багтаасан нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах, хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний хүлээх үүрэг хариуцлага бол өөрсдийн гүйцэтгэсэн аудитад тулгуурлан эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт илэрхийлэх явдал юм. Бид АОУС-ын дагуу аудитаа хийж гүйцэтгэсэн болно. Ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөн, нэгтгэсэн санхүүгийн тайлангууд материаллаг алдаатай эсэх талаар ул үндэслэлтэй баталгаажуулалт олж авахын тулд аудитыг төлөвлөж гүйцэтгэхийг эдгээр стандартууд биднээс шаарддаг.

Аудитаар нэгтгэсэн санхүүгийн тайлангууд дахь дүнгүүд болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэдэг. Сонгосон горимууд нь аудиторын үнэлэмж, түүний дотор залилан эсвэл алдаанаас шалтгаалсан, уг

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

нэгтгэсэн санхүүгийн тайлангууд дахь материаллаг алдаатай тайлагналын эрсдэлийн үнэлгээнээс хамаардаг.

Эдгээр эрсдэлийн үнэлгээг хийхдээ аудитор нь тухайн байгууллагын дотоод хяналтын үр өгөөжийн талаар дүгнэлт гаргах зорилго тавилгүйгээр тухайн нөхцөл байдалд тохиромжтой аудитын горимуудыг зохиомжлохын тулд нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг байгууллаг бэлтгэж, үнэн зөв толилууллагатай хамаатай дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн аудитаар тухайн хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн зохистой байдал болон тооцооллын ул үндэслэлийг үнэлж мөн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын шийт толилуулгыг үнэлдэг.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр компанийн удирдлагаас бэлтгэн танилцуулсан 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн тайлан, орлого үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу илэрхийлсэн байна.

Захирал, МНБ

В.Оюунчимэг

2013.03.01

ОРШИЛ

"Тэд Аудит" ХХК, "Бэрэн майнинг" ХК-ний хооронд байгуулсан гэрээг үндэслэн "Бэрэн майнинг" ХК-ны 2012 оны Санхүүгийн тайланд хийсэн аудитыг дуусгавар болгосон тухай энэхүү тайланг "Бэрэн майнинг" ХК-ний ТУЗ-д толилуулж байна.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу явуулав.

"Бэрэн майнинг" ХК -ны 2012 оны 12 сарын 31-наархи санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго байв.

"Бэрэн майнинг" ХК нь санхүүгийн тайлангаа Сангийн сайдын баталсан заавар, журам, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Энэхүү тайланд нягтлан бодох бүртгэл, санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах талаархи бидний зөвлөмжүүд тусгагдсан.

Аудитаар хөндөгдсөн асуудлуудыг дор нэгтгэн тайлбарлав.

Санхүүгийн дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Ийнхүү дахин хянахдаа "Бэрэн майнинг" ХК -ны хяналтыг санхүүгийн эрсдэл ба хяналтын талаарх өөрийн мэдээллийн сантай харьцуулан шинжилгээ хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах боломж олгосон.

Тухайн тайлант хугацаанд асуудал үүсгэсэн эдгээр хяналтыг бид "Бэрэн майнинг" ХК-ны ТУЗ-д жич тайлагнаж байна.

Аудитаар дээд түвшний хяналтын асуудлаар хөндөгдсөн зүйл байхгүй.

Байгууллагын удирдлага, ТУЗ-аас заавал анхаарал хандуулах гол асуудлыг дурьдвал:

- ✓ Анхан шатны баримтын иж бүрдлийг ханган ажиллаж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан ажиллах
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан өөрийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах
- ✓ Дансны өглөг, авлагыг тооцоо нийлж баталгаажуулдаг байх, өглөг авлагын дэлгэрэнгүй бүртгэлийн судалгааг насжилтаар нь бүртгэх

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭМЭЛТ ТОДРУУЛГА

1. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

"Бэрэн майнинг" ХК нь 2 үүсгэн байгуулагчтай. 9011275052 тоот улсын бүртгэлийн дугаартай 2886219 тоот регистртэй. Үйл ажиллагааны чиглэл нь: Гадаад дотоод худалдаа, Ашигт малтмалын хайгуул хийх.

Компаний өөрийн хөрөнгө буюу дүрмийн сан нь 273,916,975.9 мянган төгрөгийн хөрөнгөтэй бөгөөд энэхүү хөрөнгө нь нэг бүр нь 157.35 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,740,813,320 ширхэг хувьцаа байна. Нийт хувьцаа нь:

- Бэрэн групп ХХК 35,70%
- Бэрэн майнинг ХК 30,00%
- Сор металл ХХК 34,30%-ийг тус тус эзэмшдэг.

"Бэрэн майнинг" ХК -ний Захирлаар Б.Мөнхдалай ажиллан өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж 1-р гарын үсгийг зурдаг. Ерөнхий нягтлан бодогчоор н. Мөнхтайван ажиллаж 2-р гарын үсэг зурдаг.

2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

Санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Санхүү Эдийн Засгийн сайдын 2002 оны 171/11 болон 191 тоот тушаалаар баталсан аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт маягт, журнал, бүртгэлийн системийн маягтын дагуу бүртгэл хөтөлж, тус яамны сайдын 2004 оны 248 тоот тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн маягт, хавсралтын дагуу тайланг бэлтгэдэг.

Сангийн яам болон Татварын ерөнхий газарт санхүүгийн тайлан, татварын тайлан, холбогдох тайлан мэдээг гаргаж хүргүүлдэг байна.

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО

Байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа бөгөөд цаашид ч үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөлд үндэслэн, тасралтгүй үйл ажиллагааны зарчмаар санхүүгийн тайлангаа бэлтгэдэг.

а) Тайлагналын суурь

Нягтлан бодох бүртгэлийг хөтлөхдөө аккруэль суурийг баримталдаг.

б) Тайлагнасан валют

Санхүүгийн тайланг Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулинд зааснаар Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлсэн байна.

в) мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах зүйл

Мөнгөн хөрөнгө нь ХААН банкин дахь харилцах данс болон кассанд байгаа бэлэн мөнгөнөөс бүрддэг. Валютыг тухайн үеийн Монгол банкны ханшаар хөрвүүлэн бүртгэдэг.

г) Авлага

Авлага нь үүссэн үеийн нэхэмжлэгдэх үнийн дүнгээр бүртгэдэг. Авлагын дэлгэрэнгүй бүртгэл хөтлөж, авлагын товчоо тайлан гаргаагүй байна.

д) Бараа материал

Түүхий эд материалын өртгийг худалдаж авсан өртгөөр нь бараа материалын бүртгэлийн байнгын системийг ашиглан бүртгэлд тусгадаг бөгөөд зарлага болгохдоо дундаж өртгийн аргыг хэрэглэдэг.

е) Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анхны өртгөөр нь буюу худалдан авсан үнэ дээр тээвэрлэх суурилуулахтай холбогдон гарсан зардлыг нэмсэн дүнгээр бүртгэдэг.

Элэгдлийг Монгол Улсын Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татварын тухай хуулийн дагуу шулуун шугамын аргаар байгуулдаг.

ё) Эзэмшигчдийн өмч

Эзэмшигчийн өмчийн хэсэгт хувьцаат капитал, дахин үнэлгээний нөөц, хуримтлагдсан үр дүнг бүртгэсэн. 2012-02-15-ны өдөр Улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрийн хөрөнгийн хэмжээ 273,916,975.9 мянган төгрөг гэж байхыг 1,740,813,320 ширхэг хувьцааны тоогоор бүртгэж алдаатай бүртгэсэн байна. Иймд Улсын бүртгэлийн гэрчилгээний өөрийн хөрөнгийн хэмжээг залруулан бүртгүүлж авах шаардлагатай.

ж) Орлого санхүүжилт, зардал

Орлогыг хэрэгжсэн буюу хэрэгжих боломжтой болсон тохиолдолд хүлээн зөвшөөрдөг. Тайлант онд төмрийн баяжмал олборлож борлуулснаас орлого олж ажилласан байна.

Үйл ажиллагааны зардлыг орлого зардал уялдах зарчмыг баримтлан тайлант хугацаанд хуримтлуулан бүртгэдэг.

з) Татвар

Ажиллагсдын цалингаас болон хувь хүнээр гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнээс Хувь хүний орлогын албан татварыг суутган тооцож төлдөг. Ашигт малтмалын нөөц

ашигласны төлбөр, үл хөдлөх хөрөнгийн татвар, авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслэлийн албан татварыг тооцон төлдөг.

4. МӨНГӨН ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгийг дараах байдлаар тайланд тусгасан./төгрөгөөр/

| | 2011.12.31 | 2012.12.31 |
|---------------------------------|----------------------|-------------------|
| Мөнгөн хөрөнгийн төрөл | | |
| Касс дахь бэлэн мөнгө | | |
| ✓ Касс дахь бэлэн төгрөг | 3,341,510.46 | 543,279.96 |
| ✓ Касс дахь бэлэн доллар | 00.0 | 00.0 |
| Харилцах дахь мөнгө | | |
| ✓ ХААН банк төгрөг - 5038014413 | 22,602,982.54 | 32,241.54 |
| Мөнгөн хөрөнгийн дүн | 25,944,493.00 | 575,521.50 |

Банкны харилцах дансдын үлдэгдэлд тулган баталгаажуулалт хийгдээгүй, бэлэн мөнгөний тооллого хийж тооцоо бодоогүй байна. Дансны үлдэгдэл 543,3 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

5. АВЛАГА

Богино хугацаат авлагын тооцоо дараах байдлаар тайланд тусгагдсан байна.

| Авлагын ангилал | 2011.12.31 | 2012.12.31 |
|--------------------|-----------------------|-----------------------|
| ✓ Дансны авлага | 290,588,904.00 | 268,070,604.00 |
| ✓ Бараа материал | 38,797,649.00 | 16,321,841.00 |
| ✓ Ар ган ХХК | 42,403,044.00 | 42,403,044.00 |
| ✓ НӨАТ-ын авлага | 0.00 | 3,722,400.00 |
| ✓ ААНОАТ-ын авлага | 5,443,800.00 | 5,443,800.00 |
| Дүн | 296,022,704.00 | 277,226,804.00 |

Авлагаас үлдэгдлийг тооцоо нийлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Бараа материалын 16,3 сая төгрөгийн авлага нь тодорхойгүй байна.

6. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ/ТООЦОО

Урьдчилж төлсөн зардлын тооцоо дараах байдлаар тайланд тусгагдсан байна.

| Үзүүлэлт | 2011.12.31 | 2011.12.31 |
|------------------------|-------------|-----------------------|
| Урьдчилж төлсөн зардал | 00,0 | 133,103,602.00 |
| Дүн | 00,0 | 133,103,602.00 |

Урьдчилж төлсөн зардлын тооцооны задаргаа байхгүй.

7. БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалыг дараах байдлаар тайланд тусгасан.

| Үзүүлэлт | 2011.12.31 | 2011.12.31 |
|-------------------------|-----------------------|-----------------------|
| ✓ Сэлбэг | 208,345,200.00 | 55,846,497.00 |
| ✓ Хүнс | 18,205,360.00 | 10,381,004.00 |
| ✓ Аж ахуй | 32,500,600.00 | 278,940.00 |
| ✓ Хөдөлмөр хамгаалал | 9,325,000.00 | 338,340.00 |
| ✓ Шатах тослох материал | 28,906,500.00 | 78,809,443.00 |
| ✓ Хүдэр | 0,00 | 219,292,783,70 |
| ✓ Тэсрэх материал | 0,00 | 22,474,721.00 |
| Дүн | 297,292,600.00 | 387,421,728.70 |

Бараа материалын анхан шатны баримтын бүрдэлт дутуу, дансны кодчлол хийгдээгүй, тооллого хийж, тооцоо бодолт хийгдээгүй байна.

8. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

а) Үндсэн хөрөнгийг дараах байдлаар тайланд тусгасан.

| Хөрөнгийн нэр | Оны эхэнд | нэмэгдсэн | хасагдсан | Оны эцэст |
|------------------------|-----------------------|--------------------|-------------|-----------------------|
| Барилга байгууламж | 1,371,225,938 | 0,00 | 0,00 | 1,371,225,938 |
| Авто тээврийн хэрэгсэл | 1,253,109,024 | 32,213,520 | 0,00 | 1,285,322,544 |
| Машин тоног төхөөрөмж | 14,563,265,437 | 347,537,046 | 0,00 | 14,910,802,483 |
| Тавилга, эд хогшил | 14,475,483 | 0,00 | 0,00 | 14,475,483 |
| Бусад хөрөнгө | 509,910,768 | 0,00 | 0,00 | 509,910,768 |
| Биет бус хөрөнгө | 0,00 | 3,503,955,00 | | 4,703,955,00 |
| Нийт дүн | 17,711,986,650 | 379,750,566 | 0,00 | 18,091,737,216 |

Тайлант онд үндсэн хөрөнгө 379,750.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

б) Үндсэн хөрөнгийн элэгдэл

| Хөрөнгийн нэр | Оны эхэнд | нэмэгдсэн | хасагдсан | Оны эцэст |
|------------------------|--------------------|--------------------|-------------|--------------------|
| Барилга байгууламж | 29,418,455 | 14,709,228 | | 44,127,683 |
| Авто тээврийн хэрэгсэл | 26,744,050 | 13,372,025 | 0,00 | 40,116,075 |
| Машин тоног төхөөрөмж | 317,108,027 | 158,554,014 | 0,00 | 475,662,041 |
| Тавилга, эд хогшил | 8,787,332 | 4,393,665 | 0,00 | 13,180,997 |
| Бусад хөрөнгө | 1,031,684 | 0,00 | 0,00 | 1,031,684 |
| Биет бус хөрөнгө | 0,00 | 0,00 | | 0,00 |
| Нийт дүн | 383,089,548 | 191,028,932 | 0,00 | 574,118,480 |

Хөрөнгийн элэгдлийг татварын зорилгоор байгуулсан, балансын тодруулга тайлан дээр элэгдлийн дүнг зөрүүтэй тусгасан байна. МУ-ийн Засгийн Газрын 2005 оны 233-р тогтоолыг баримтлаагүй байна.

9. ӨР ТӨЛБӨР

| Үзүүлэлт | 2011.12.31 | 2011.12.31 |
|-------------------|----------------------|----------------------|
| ✓ Дансны өглөг | 3,114,714,368 | 3,796,469,992 |
| ✓ Цалингийн өглөг | 0,00 | 982,560.00 |
| ✓ ХХОАТ-н өглөг | 25,271,700.00 | 2,430,000,00 |
| ✓ НӨАТ-н өглөг | 34,050,800.00 | 0,00 |
| Дүн | 3,174,036,868 | 3,799,882,552 |

Дансны өглөгийн 3,796,469.9 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

10. ӨМЧ

Өмчийг дараах байдлаар тайланд тусгасан.

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Нэмэгдсэн | Хорогдсон | Эцсийн үлдэгдэл |
|-----------------------|--------------------------|------------------------|-------------|---------------------------|
| Хувьцаат капитал | 16,700,724,077.21 | 0,00 | 0,00 | 16,700,724,077.21 |
| Дахин үнэлгээний нөөц | 274,530,876.80 | 0,00 | 0,00 | 274,530,876.80 |
| Хуримтлагдсан үр дүн | -1,061,281,200.57 | 256,685,024,149 | 0,00 | 255,623,742,948.43 |
| Дүн | 15,913,973,753.43 | 256,685,024,149 | 0,00 | 272,598,997,902.44 |

Тайлант хугацаанд 256,685,024,149 төгрөгөөр эздийн өмч нэмэгдсэн нь Төмрийн хүдрийн баяжуулах үйлдвэрийн хөрөнгө, Төмрийн хүдрийн ордийн ашиглалтын лицензийн үнэлгээ, баяжмал үйлдвэрлэх хүчин чадал бүхий Шууд ангижруулах үйлдвэрийн бизнесийн үнэ цэнийг тогтоолгож, хөрөнгийн үнэлгээ хийлгүүлсэн үнэ цэнээр нэмэгдсэн байна.

11. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

| Орлогын төрөл | 2011.12.31 | 2012.12.31 |
|-----------------------------|-------------|-------------------------|
| Борлуулалтын орлого-Баяжмал | | 1,635,150,384.00 |
| Нийт орлого | 0.00 | 1,635,150,384.00 |

Тайлант онд 13,179,8 тн төмрийн баяжмал олж борлуулснаас 1,635,150.4 мянган төгрөгийн орлогыг олсон байна.

12. БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ, ЗАРДАЛ

| Зардлын зүйл анги | 2011.12.31 | 2012.12.31 |
|---|------------|--------------------|
| ✓ Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | | 1,072,603,700 |
| Үйл ажиллагааны зардал | | |
| ✓ Цалин хөлс болон түүнтэй холбоотой зардал | | 232,240,438 |
| ✓ Нийгмийн хамгааллын шимтгэл | | 20,765,214 |
| ✓ Элэгдлийн зардал | | 191,028,900 |
| ✓ Албан томилолтын зардал | | 4,894,932 |
| ✓ Шуудан холбоо | | 24,948,700 |
| ✓ Хөдөлмөр хамгаалал | | 28,650,600 |
| ✓ Түүхий эд материалын зардал | | 44,372,400 |
| ✓ Шатахууны зардал | | 6,461,800 |
| ✓ Тээврийн зардалд | | 16,042,100 |
| ✓ Бусад бараа үйлчилгээний зардал | | 249,838,400 |
| Нийт зардлын дүн | | 819,243,484 |

Тайлант онд үндсэн бус үйл ажиллагааны хэсэгт гүйлгээ хийгдээгүй байна.

10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВЦ

2013 оны 1-р сарын байдлаар "Бэрэн майнинг" ХК-ний ажиллагаа хэвийн явагдаж байгаа бөгөөд санхүүгийн тайланд нөлөөлөхүйц үйл явдал болоогүй.


"ТЭД АУДИТ" ХХК

"БЭРЭН МАЙНИНГ" ХК
АУДИТЛАГДСАН БАЛАНС
2012 ОНЫ 12-Р САРЫН 31-НЭЭРХ
(төгрөгөөр)

ХӨРӨНГӨ

| | 2011.12.31 | 2012.12.31 |
|------------------------------------|--------------------------|---------------------------|
| 1. Эргэлтийн хөрөнгө | | |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 25,944,493.00 | 575,521.50 |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт | | |
| Үнэлгээний хасагдуулга | | |
| Дансны авлага | 290,588,904.00 | 268,070,604.00 |
| Найдваргүй авлагын хасагдуулга | | |
| Бусад авлага | 5,433,800.00 | 9,156,200.00 |
| Бараа материал | 321,572,655.78 | 387,421,728.78 |
| Дуусаагүй үйлдвэрлэл | | |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | | 133,103,602.00 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 643,539,852.78 | 798,327,656.28 |
| 2. Эргэлтийн бус хөрөнгө | | |
| Үндсэн хөрөнгө | 17,202,075,882.70 | 17,202,075,882.70 |
| Хуримтлагдсан элэгдэл | (382,057,864.50) | (573,086,796.00) |
| Бусад үндсэн хөрөнгө | 509,910,768.00 | 889,661,334.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (1,031,684.82) | (1,031,684.82) |
| Дуусаагүй барилга | 554,087,578.27 | 554,087,578.27 |
| Уурхайн хөрөнгө | 41,991,301.81 | |
| Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө | | 256,941,720,948.00 |
| Хайгуул үнэлгээний хөрөнгө | 519,494,787.19 | 587,125,535.00 |
| Үнэлгээний хасагдуулга | | |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 18,444,470,768.65 | 275,600,552,797.15 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 19,088,010,621.43 | 276,398,880,453.43 |

АУДИТОР



/С.ОЮУНГЭРЭЛ/

"Бэрэн майнинг" ХК
 Санхүүгийн тайлангийн аудит
 2012 оны 12 дугаар сарын 31-нээрх дуусгавар болсон

"Тэд Аудит" ХХК

**"БЭРЭН МАЙНИНГ" ХК
 АУДИТЛАГДСАН БАЛАНС
 2012 ОНЫ 12-Р САРЫН 31-НЭЭРХ
 (төгрөгөөр)**

ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

| ӨР ТӨЛБӨР | 2011.12.31 | 2012.12.31 |
|---|--------------------------|---------------------------|
| 1. Богино хугацаат өр төлбөр | | |
| Дансны өглөг | 3,114,714,368.00 | 3,796,469,992.00 |
| Цалингийн өглөг | | 982,560.00 |
| Орлогын татварын өглөг | | |
| ХАОАТ-ын өглөг | 25,271,700.00 | 2,430,000.00 |
| НӨАТ-ын өглөг | 34,050,800.00 | |
| Бусад татварын өглөг | | |
| ЭМНД-ын шимтгэлийн өглөг | | |
| Ноогдол ашгийн өглөг | | |
| Банкны богино хугацаат зээл | | |
| Бусад өглөг | | |
| Урьдчилж орсон орлого | | |
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | 3,174,036,868.00 | 3,799,882,552.00 |
| 2. Урт хугацаат өр төлбөр | | |
| Урт хугацаат зээл | | |
| Бусад урт хугацаат өглөг | | |
| Урт хугацаат өр төлбөрийн дүн | - | - |
| Өр төлбөрийн нийт дүн | 3,174,036,868.00 | 3,799,882,552.00 |
| Эзэмшигчдийн өмч | | |
| Өмч: а) Төрийн | | |
| б) Хувийн | 16,700,724,077.21 | 273,916,975,902.00 |
| Хувьцаат капиталын дүн | 16,700,724,077.21 | 273,916,975,902.00 |
| Дахин үнэлгээний нөөц | 274,530,876.79 | |
| Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг | | |
| Хуримтлагдсан ашиг /алдагдал/ | (1,061,281,200.57) | (1,317,978,000.57) |
| Тайлант үеийн | | (256,696,800.00) |
| Өмнөх үеийн | (1,061,281,200.57) | (1,061,281,200.57) |
| Эзэмшигчдийн өмчийн дүн | 15,913,973,753.43 | 272,598,997,901.43 |
| ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН | 19,088,010,621.43 | 276,398,880,453.43 |

АУДИТОР




/С.ОЮУНГЭРЭЛ/

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

"БЭРЭН МАЙНИНГ" ХК
АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ТАЙЛАН
2012 ОНЫ 12-Р САРЫН 31-НЭЭРХ
(төгрөгөөр)

| | 2011.12.31 | 2012.12.31 |
|---|-------------------------|-------------------------|
| Үндсэн үйл ажиллагааны орлого | 2,147,917,644.00 | 1,635,150,384.00 |
| Хөрөнгө оруулалтын орлого | | |
| Бусад орлого | | |
| Борлуулалтын орлогын дүн | 2,147,917,644.00 | 1,635,150,384.00 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 1,279,996,455.30 | 1,072,603,700.00 |
| Нийт ашиг (алдагдал) | 867,921,188.70 | 562,546,684.00 |
| Үндсэн болон нэмэгдэл цалин | 297,805,604.00 | 232,240,438.00 |
| Нийгмийн даатгалын шимтгэл | 39,798,404.00 | 20,765,214.00 |
| Засвар үйлчилгээний зардалд | 6,891,510.00 | 10,310,200.00 |
| Ашиглалтын зардал | 114,136,957.00 | |
| Түрээсийн зардал | 7,440,250.00 | |
| Албан томилолтын зардал | 25,795,906.00 | 4,894,932.00 |
| Тээврийн зардал | 11,337,560.00 | 16,042,100.00 |
| Түүхий эд материалын зардалд | 122,736,428.70 | 44,372,400.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн үйлчилгээ | | |
| Элэгдлийн зардал | 250,507,605.00 | 191,028,900.00 |
| Зар сурталчилгаа | 53,021,270.00 | |
| Бичиг хэрэг | | |
| Шуудан холбооны зардал | 6,769,110.00 | 24,948,700.00 |
| Шатахууны зардал | 3,693,200.00 | 6,461,800.00 |
| Хөдөлмөр хамгаалал, харуул хамгаалалт | 18,116,070.00 | 28,650,600.00 |
| Шагнал урамшууллын зардал | 32,738,363.00 | 29,642,600.00 |
| Зээлийн хүүгийн зардал | 1,120,000.00 | |
| Газрын төлбөр | | |
| Бусад зардал | 15,573,000.00 | 209,885,600.00 |
| Үйл ажиллагааны зардлын дүн | 1,007,481,237.70 | 819,243,484.00 |
| Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/ | (139,560,049.00) | (256,696,800.00) |
| Үндсэн бус үйл ажиллагааны ашиг /алдагдал/ | | |
| Үндсэн бус үйл ажиллагааны ашиг, алдагдал | | |
| Торгууль, хөнгөлөлтийн ашиг алдагдал | | |
| Ноогдол ашгийн орлого | | |
| Валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн ашиг, алдагдал /хэрэгжсэн/ | | |
| Валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн ашиг, алдагдал /хэрэгжээгүй/ | | |
| Үндсэн бус үйлдвэрлэл үйлчилгээний ашиг | | |
| Бусад | | |
| Үндсэн бус үйлдвэрлэл үйлчилгээний ашиг(алдагдал)-ын дүн | - | - |
| Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | (139,560,049.00) | (256,696,800.00) |
| Орлогын татварын зардал | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | (139,560,049.00) | (256,696,800.00) |


АУДИТОР



/С.ОЮУНГЭРЭЛ/

"БЭРЭН МАЙНИНГ" ХК
 АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
 2012 ОНЫ 12-Р САРЫН 31-НЭЭРХ
 (төгрөгөөр)

| | Хувьцаат капитал | Нэмж төлөгдсөн капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|--|--------------------|------------------------|-----------------------|--------------------|--------------------|
| 2011 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 24,200,724,077.21 | | 274530876.8 | (921,721,151.57) | 23,553,533,802.44 |
| Эртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | |
| руулсан үлдэгдэл | | | | | |
| дсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | |
| хөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт ралт | (7,500,000,000.00) | | | | (7,500,000,000.00) |
| Гаднаад валютын хөрвүүлэлтийн нөөц | | | | | |
| бодлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, | | | | | |
| лант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | (139,560,049.00) | (139,560,049.00) |
| Тооцдол ашиг | | | | | |
| гасан хувьцаат капитал | | | | | |
| 2 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 16,700,724,077.21 | - | 274,530,876.80 | (1,061,281,200.57) | 15,913,973,753.44 |
| Эртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | |
| руулсан үлдэгдэл | | | | | |
| дсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | |
| Хөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт ралт | | | | | |
| Гаднаад валютын хөрвүүлэлтийн нөөц | | | | 256,941,720,949 | 256,941,720,949.00 |
| бодлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, | | | | | |
| лант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | | |
| Тооцдол ашиг | | | | (256,696,800.00) | (256,696,800.00) |
| гасан хувьцаат капитал | | | | | |
| 2 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 16,700,724,077.21 | - | 274,530,876.80 | 255,623,742,948.43 | 272,598,997,902.44 |

АУДИТОР  /С.ОЮУНГЭРЭЛ/

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү тайлангийн саллигүй хэсэг болно.

"БЭРЭН МАЙНИНГ" ХК
АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2012 ОНЫ 12-Р САРЫН 31-НЭЭРХ
 (төгрөгөөр)

| | Өмнөх жилийн дүн | Тайлант жилийн дүн |
|---|-------------------------|-------------------------|
| I. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого | 2,332,957,938.00 | 1,049,745,500.00 |
| Борлуулалтын болон худалдан авагчаас орсон орлого | 2,332,957,938.00 | 1,049,745,500.00 |
| Туслах үйл ажиллагаанаас орсон орлого | | |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | | |
| Бусад | | |
| Үндсэн үйл ажиллагын мөнгөн зарлага | 1,612,241,397.40 | 1,075,114,471.50 |
| Ажилчдад олгосон мөнгө | 214,026,021.00 | 193,135,838.00 |
| Нийгмийн даатгалын байгуулагад төлсөн мөнгө | 52,604,381.00 | 35,467,405.00 |
| Түүхий эд материал худалдан авахад төлсөн мөнгө | 607,432,364.40 | |
| Ашиглалтын зардалд төлсөн мөнгө | 297,138,117.00 | 165,764,810.50 |
| Түлш шатахуун тээврийн хөлс сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө | 433,971,714.00 | 522,985,879.50 |
| Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө | | 157,760,538.50 |
| Төлсөн хүү | | |
| Төлсөн орлогын татвар | 5,433,800.00 | |
| Даатгалын төлбөрт төлсөн мөнгө | 1,635,000.00 | |
| Бусад | | |
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 720,716,540.60 | (25,368,971.50) |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Худалдсан урт хугацаат хөрөнгийн орлого | | |
| Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө | (697,280,949) | |
| Худалдсан хөрөнгө оруулалтын орлого | | |
| Худалдаж авсан хөрөнгө оруулалт | | |
| Хүлээн авсан хүү ноогдол ашиг | | |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (697,280,949.00) | - |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Гаргасан хувьцаа | | |
| Банкнаас авсан зээл | | |
| Санхүүгийн түрээсийн өглөгийн төлбөр | | |
| Зээлийн төлөлт | | |
| Улсаас өгсөн санхүүжилт | | |
| Төрөл бүрийн хандив (+) | | |
| Урт хугацаат өрийн тайлангийн хугацааны төлөлт | | |
| Мөнгөөр эргүүлж худалдаж авсан хувьцаа | | |
| Мөнгөөр төлсөн ноогдол ашиг | | |
| Хүү ба урамшуулалын орлого | | |
| Валютын ханшийн зөрүү | | |
| Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | - | - |
| Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 23,435,591.60 | (25,368,971.50) |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 2,508,901.40 | 25,944,493.00 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 25,944,493.00 | 571,521.50 |

АУДИТОР



/С.ОЮУНГЭРЭЛ/

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.